БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/132/НА-СТА-ТШЗ**


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn



Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2022 оны 02 дугаар сар


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
3. Аудитын тайлан ....10
**3.1 Ерөнхий зүйл**....10
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ....10
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**....11
**3.4 Материаллаг байдал**....11
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**....11
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ....12
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**....13
**3.8 Аудитын гол асуудал** ....13
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ....13
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**....13
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ....14
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**....14
4. Аудитын илрүүлэлт....14
4.1 Залруулсан алдаа ....14
4.3 Зөвлөмж....15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....16

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| УСНББС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.21 № 2/30

танай ____________ -ны №____________ -т

БАЯНЛИГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭДЭНДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **93,653,543.57** | **111,940,348.29** |
| **33** | **АВЛАГА** | 918,544.00 | 5,449,398.72 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 918,544.00 | 549,398.72 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 4,900,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 4,900,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 92,734,999.57 | 106,490,949.57 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,682,856.54 | 19,031,096.54 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 13,682,856.54 | 13,682,856.54 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 5,348,240.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 78,002,143.03 | 86,409,853.03 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 559,110.00 | 559,110.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 77,443,033.03 | 85,551,743.03 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 299,000.00 |
| 35600 | Мал амьтад | 1,050,000.00 | 1,050,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,785,703,308.80** | **4,579,066,028.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,785,703,308.80 | 4,579,066,028.03 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,745,573,308.80 | 4,538,936,028.03 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,983,045,331.02 | 4,983,045,331.02 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -453,882,896.40 | -645,070,348.32 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 15,500,000.00 | 15,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,500,000.00 | -15,500,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 283,771,783.14 | 307,727,907.14 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -209,423,451.22 | -225,594,056.32 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 226,957,866.20 | 223,038,411.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -110,198,376.94 | -130,727,269.69 |
| 39217 | Ном | 25,303,053.00 | 26,516,053.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40,130,000.00 | 40,130,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,130,000.00 | 40,130,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,879,356,852.37** | **4,691,006,376.32** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **460,667.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 460,667.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 460,667.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 460,667.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,879,356,852.37** | **4,690,545,709.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,879,356,852.37 | 4,690,545,709.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 514,828,217.20 | 514,828,217.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 514,828,217.20 | 514,828,217.20 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,713,573,171.48 | 3,524,762,028.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,713,573,171.48 | 3,713,573,171.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -188,811,143.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 650,955,463.69 | 650,955,463.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,879,356,852.37** | **4,691,006,376.32** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,502,419,746.98** | **1,367,851,415.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **45,833,696.98** | **2,743,247.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 29,450,069.98 | 2,743,247.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 22,396,349.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 22,396,349.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 7,053,720.98 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 16,383,627.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 16,383,627.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **260,364,050.00** | **259,546,268.68** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,196,222,000.00 | 1,105,561,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 56,178,350.00 | 49,520,913.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56,178,350.00 | 45,185,770.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 4,335,143.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 204,185,700.00 | 210,025,355.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 204,185,700.00 | 210,025,355.68 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,702,998,499.65** | **1,556,154,495.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,702,998,499.65** | **1,556,154,495.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,509,841,383.48 | 1,471,275,433.17 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 849,050,219.76 | 853,258,116.63 |
| 210101 | Үндсэн цалин | 849,050,219.76 | 853,258,116.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 106,653,117.00 | 110,419,095.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 77,845,352.00 | 110,419,095.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,326,168.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,797,092.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,425,865.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,258,640.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 193,337,890.05 | 200,025,355.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,337,140.05 | 5,306,105.68 |
| 210302 | Түлш, халаалт | 187,220,750.00 | 194,719,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 780,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,070,928.00 | 9,001,525.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,193,000.00 | 2,665,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,002,928.00 | 1,389,525.10 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,788,000.00 | 1,796,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 18,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 960,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,659,000.00 | 2,190,400.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,230,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,589,900.00 | 31,020,672.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,108,850.00 | 3,222,347.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,882,050.00 | 25,600,325.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,599,000.00 | 2,198,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,515,600.00 | 15,168,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 265,000.00 | 210,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,250,600.00 | 14,958,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,047,000.00 | 682,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,047,000.00 | 682,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,206,400.00 | 5,383,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,756,400.00 | 4,453,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 480,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 283,370,328.67 | 246,317,067.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 7,245,850.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,132,000.00 | 2,103,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 275,238,328.67 | 236,968,217.87 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 193,157,116.17 | 84,879,062.66 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77,405,850.00 | 68,299,270.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,507,500.00 | 22,345,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,660,200.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,518,150.00 | 45,185,770.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,720,000.00 | 768,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,720.98 | 39,043.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,720.98 | 39,043.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,847,809.95 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,847,809.95 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 107,901,735.24 | 16,540,749.66 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 107,901,735.24 | 16,540,749.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-200,578,752.67** | **-188,303,080.15** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 508,062.90 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 508,062.90 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -508,062.90 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-200,578,752.67** | **-188,811,143.05** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 474,698,217.20 | 00.00 | 5,094,471,298.76 | 5,569,169,515.96 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **474,698,217.20** | **00.00** | **5,094,471,298.76** | **5,569,169,515.96** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 40,130,000.00 | 00.00 | -1,028,298,023.19 | -988,168,023.19 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **514,828,217.20** | **650,955,463.69** | **3,713,573,171.48** | **4,879,356,852.37** |
| D01 | **2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **514,828,217.20** | **650,955,463.69** | **3,713,573,171.48** | **4,879,356,852.37** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **514,828,217.20** | **650,955,463.69** | **3,713,573,171.48** | **4,879,356,852.37** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -188,811,143.05 | -188,811,143.05 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **514,828,217.20** | **650,955,463.69** | **3,524,762,028.43** | **4,690,545,709.32** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,463,639,770.98** | **1,365,108,168.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,053,720.98** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 7,053,720.98 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 7,053,720.98 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,456,586,050.00** | **1,365,108,168.68** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,196,222,000.00 | 1,105,561,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 56,178,350.00 | 49,520,913.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56,178,350.00 | 45,185,770.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 4,335,143.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 204,185,700.00 | 210,025,355.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 204,185,700.00 | 210,025,355.68 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,425,159,770.98** | **1,334,269,168.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,425,159,770.98** | **1,334,269,168.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,232,002,654.81** | **1,249,390,106.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 850,287,554.00 | 852,454,200.24 |
| 210101 | Үндсэн цалин | 601,614,142.00 | 635,524,657.05 |
| 210102 | Нэмэгдэл | 158,908,819.90 | 162,486,785.00 |
| 210104 | Урамшуулал | 89,764,592.10 | 54,442,758.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 106,170,382.76 | 110,393,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,471,506.00 | 80,429,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,532,094.00 | 7,490,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,586,047.76 | 5,992,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,597,432.00 | 1,498,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,983,303.00 | 14,981,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 193,337,890.05 | 200,025,355.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,337,140.05 | 5,306,105.68 |
| 210302 | Түлш, халаалт | 187,220,750.00 | 194,719,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 780,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,841,928.00 | 11,157,625.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,339,500.00 | 1,411,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,002,928.00 | 1,389,525.10 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,788,000.00 | 2,036,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 48,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 980,000.00 | 960,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,683,500.00 | 5,360,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,408,900.00 | 32,644,125.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,050,850.00 | 4,159,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,882,050.00 | 25,600,325.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,476,000.00 | 2,884,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,515,600.00 | 20,220,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 265,000.00 | 361,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,250,600.00 | 19,858,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,047,000.00 | 682,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,047,000.00 | 682,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,406,400.00 | 5,640,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,956,400.00 | 4,950,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,987,000.00 | 16,173,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 13,213,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,987,000.00 | 2,959,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **193,157,116.17** | **84,879,062.66** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77,405,850.00 | 68,299,270.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,507,500.00 | 22,345,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,660,200.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,518,150.00 | 45,185,770.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,720,000.00 | 768,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,847,809.95 | 39,043.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 107,903,456.22 | 16,540,749.66 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 107,903,456.22 | 16,540,749.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **38,480,000.00** | **30,839,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **38,480,000.00** | **30,839,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **38,480,000.00** | **30,839,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 38,480,000.00 | 30,839,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 38,480,000.00 | 30,839,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-38,480,000.00** | **-30,839,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,327,791,100.00 | 1,299,046,506.02 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,327,791,100.00 | 1,299,046,506.02 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,301,423,500.00 | 1,275,933,006.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 856,726,800.00 | 852,454,200.24 |
| 210101 | Үндсэн цалин | 653,496,900.00 | 635,524,657.05 |
| 210102 | Нэмэгдэл | 149,309,400.00 | 162,486,785.00 |
| 210104 | Урамшуулал | 53,920,500.00 | 54,442,758.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 110,393,200.00 | 110,393,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,429,900.00 | 80,429,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,490,900.00 | 7,490,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,992,700.00 | 5,992,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,498,100.00 | 1,498,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,981,600.00 | 14,981,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 212,229,200.00 | 200,025,355.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,547,200.00 | 5,306,105.68 |
| 210302 | Түлш, халаалт | 205,452,000.00 | 194,719,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 230,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,702,800.00 | 12,370,625.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,486,900.00 | 1,411,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,400,000.00 | 1,389,525.10 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,998,100.00 | 2,036,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,212,600.00 | 1,213,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,240,000.00 | 960,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,365,200.00 | 5,360,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,062,600.00 | 32,644,125.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,172,800.00 | 4,159,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,005,300.00 | 25,600,325.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,884,500.00 | 2,884,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 49,848,100.00 | 49,846,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,988,000.00 | 29,987,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,860,100.00 | 19,858,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 691,000.00 | 682,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 691,000.00 | 682,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,582,400.00 | 1,344,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 842,400.00 | 654,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16187400.00 | 16173200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,222,200.00 | 13,213,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,965,200.00 | 2,959,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26367600.00 | 23113500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,367,600.00 | 23,113,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,593,400.00 | 22,345,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 774,200.00 | 768,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,327,791,100.00 | 1,299,046,506.02 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,105,561,900.00 | 1,089,021,150.34 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,105,561,900.00 | 1,089,021,150.34 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 222,229,200.00 | 210,025,355.68 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 222,229,200.00 | 210,025,355.68 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 66.00 | 68.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 51.00 | 53.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14.00 | 14.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 745.00 | 745.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 745.00 | 745.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 745.00 | 745.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **70.00** | **70.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 55.00 | 55.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15.00 | 15.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21,770,760.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,770,760.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,296,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,296,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,296,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17474660.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,474,660.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | -27,711,110.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,185,770.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 17474660.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 17,474,660.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,474,660.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа бараа материалын үнийг тодорхой тусгах, онцгой комиссоос олгож байгаа зардлын анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын шийдвэрийг бүрэн байршуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 73 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

Тайланд жил хөрөнгө зарцуулахад нэг дүгээр гарын үсгийн дарга С.Цэдэндорж, хоёр дугаар гарын үсгийг 1-8 сард нягтлан бодогч Т.Төмөрчөдөр, 9-12 сард Б.Нарангэрэл нар зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжих замаар сурлагын чанарт ахиц гаргах багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлнэ. Сурагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх" эрхэм зорилгыг тавьж, БСШУЯ, аймгийн БСУГ-аас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс хичээл, сургалтыг үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

2020-2021 оны хичээлийн жилд 5:9 ийн зарчмаар хичээл сургалтын үйл ажиллагааг явуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж аваагүй, аудитад ашиглах баримт материал байхгүй байсан ба дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,702,998.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,030.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13,624.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 12,449.2 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,691,006.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 93,978.29 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*Мян.төг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 93,653.5 | 111,940.3 | 18,286.8 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 918.5 | 5,449.4 | 4,530.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 92,735.0 | 106,490.9 | 13,756.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,785,703.3 | 4,579,066.0 | (206,637.3) |
| Үндсэн хөрөнгө | 5,574,708.0 | 5,595,957.7 | 21,249.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (789,004.7) | (1,016,891.7) | (227,886.9) |
| Нийт хөрөнгө | 4,879,356.9 | 4,691,006.4 | (188,350.5) |
| Өр төлбөр | - | 460.7 | 460.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,879,356.9 | 4,690,545.7 | (188,811.1) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 4,879,356.9 | 4,691,006.4 | (188,350.5) |

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 4,530.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь оны эцэст засварын материал авахаар шилжүүлсэн боловч хөрөнгө нь ирээгүй тул санхүүгийн тайлангийн завсрын аудитаар залруулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 106,490.9 мянган төгрөг болж өмнөх оноос 13,756.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аж ахуйн материал 8,108.7, эм боох материал 5,348.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,595,957.7 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 21,249.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29,626.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,213.0 мянган төгрөгийн ном худалдан авч, аймгийн ИТХ-ын 2021.10.15-ны өдөр 116 дугаартай тогтоолоор 9,589.3 мянган төгрөг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгээр 188,350.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,707,082.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,707,082.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 1,259,836.7 мянган төгрөгөөр баталсан 3 удаа тодотгон 1,317,791.0 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс 1,095,561.9 мянган төгрөг, орон нутгийн орлогоор 222,229.2 мянган төгрөг санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.15-ны өдрийн 6/07 тоот тогтоолоор баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,327,791.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 1257.0 мянга төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 1,261,452.5 мянган төгрөгийг зарцуулж 287.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,261,452.5 мянган төгрөг байгаа нь ажил олгогчоос төлөх цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг 258.9 мянга, газрын төлбөр 11.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 17,474.6 мянга, өндөр настны тэтгэвэр 27,711.1 мянга, сурах бичгийн үнэ 3,899.1 мянга, шалгалтын бичиг

хэргийн зардал 397.0 мянга нийт 49,520.9 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 53 ажлыг төлөвлөж, хэрэгжилт 95.6%-тай гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 дугаартай "Төсөвт зохицуулалт хийх тухай" захирамжаар тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны зардлын хэмнэлтийг багаж техник хэрэгсэл бэлтгэхэд 30,000.0 мянга, хичээл үйлдвэрлэл, БҮТЭЗ, урсгал засвар, ном худалдан авахад 24,288.8 мянган төгрөгийг зарцуулах зохицуулалт хийсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд 226,564.6 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 226,564.6 мянган төгрөгийн 87 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан, харин хуулийн 6.1.2 -д заасан батлагдсан төсөв гүйцэтгэлийн мэдээг 3-р улиралд, санхүүгийн хагас жилийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

**3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 226,185.7 мянган төгрөгөөр, тодотголоор 212229.2 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 200,025.4 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 26,160.3 мянган мянган төгрөг буюу 11.6 хувь хэмнэсэн ч ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зорим арга хэмжээний тухай" тогтоолын 1.8 дахь заалтаар 20 -оос доошгүй хувийг хэмнэх гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна./ 19076.8 мянган төгрөг/

**3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь 2021 онд дотуур байрны хүүхдийн хоолны материал 91,999.1 мянга, үдийн цайны нийлүүлэх 55,886.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ын дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газарт захиалга өгч тендерийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох “Их халбагант ХХК-тай үдийн хоол нийлүүлэх 55,878.1 мянган төгрөг, хүүхдийн дотуур байрны хоолны материал гэрээ байгуулан ажилласан байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, нийт 21,361.2 мянган төгрөгийн 5 төрлийн зөрчил илэрснээс 431.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага өгч, 20,930.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн ба төлбөрийн актыг бүрэн барагдуулж албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн ба биелэлтийг заврын аудитаар шалгасан болно.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,659.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,100.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1,559.0 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, зөрчил арилгах дахин гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлэв.

### 4.1 Залруулсан алдаа

Эм боох материалын 4.5.8 сарын орлого 1,069.9 мянган төгрөгийг нярвын тайланд орлогоор аваагүй.

Сэлбэг хэрэгслийн дансанд 2021.11.20-ны өдөр "Их халбагант" ХХК-д шилжүүлсэн төлбөрөөс 490.0 мянган төгрөгийн дугуй, суудлыг бүрээсийг ирээгүй байхад бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн.

Нэмэлт санхүүжилтийн дансны хуулгыг ерөнхий журналтай тулган шалгахад 2021.06.17-ны өдөр хөдөө орон нутагт ажилласан багш нарт олгох тэтгэмжийн 17,474.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилт хийгээгүй орхигдуулсан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2 “журналд бичих”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”-т заавал бүртгэх, санхүүгийн

тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эм боох материал 1,069.9 мянга, сэлбэг хэрэгсэл 490.0 мянган төгрөгөөр нярвын тайланг залруулж, хөдөө орон нутагт ажилласан багш нарт олгох тэтгэмжийн 17,474.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг нэмэлт санхүүжилтийн дансанд залруулан бүртгэв.

### 4.2 Төлбөрийн акт

Барилгын засварын материалд 2021 оны 11 сарын 20-ны өдөр "Их халбагант" ХХК-д шилжүүлсэн 9,011.5 мянган төгрөгийн барилгын засварын материалыг заврын аудитаар тоолж шалгахад бүргэд хаалга 3 ширхэг 2,100.0 мянга, модон хаалга 4 ширхэг 2,800.0 мянга нийт 4,900.0 мянган төгрөгийн хөрөнгийн ирээгүй байхад бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн байгааг залруулж авлагаар тусгасан ч дээрх хөрөнгөөс 2100.0 мянган төгрөгийн хөрөнгө ирээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Бэлтгэн нийлүүлэгч "Их халбагант" ХХК-аар байгууллагын дансанд нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 226,185.7 мянган төгрөгөөр, тодотголоор 212,229.2 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 200,025.4 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 26,160.3 мянган мянган төгрөг буюу 11.6 хувь хэмнэсэн ч Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зорим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалтаар 20 -оос доошгүй хувийг хэмнэх гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

2.Илрүүлэлт

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд 226,564.6 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 226,564.6 мянган төгрөгийн 87 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан, харин хуулийн 6.1.2 -д заасан батлагдсан төсөв гүйцэтгэлийн мэдээг 3-р улиралд, санхүүгийн хагас жилийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.1.2-д заасан мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянлиг сумын ЕБС | 5 | 3,669.9 | 3 | 1,559.9 | 1 | 2,100.0 | 0 | 0.0 | 2 | 0.0 |

---oOo---